



ХӨВСГӨЛ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг
Утас: 70384468
www.p-hu@inspection.gov.mn

2018.12.18

№

АХМАД НАСТНЫ АСРАМЖИЙН
ТӨВИЙН ДАРГА Ц.БАЯРСАЙХАН-Д

Зөрчлийг арилгуулах тухай

Аймгийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн 11/2807, Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн 1/166 тоот албан бичгийн дагуу Мөрөн сумын 7 дугаар багт байрлах "Ахмад настны асрамж үйлчилгээний төв"-ийн үйл ажиллагаанд Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Эрүүл мэндийн тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл ахуйн тухай, Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5823:2016 стандартын хэрэгжилт, асрамж үйлчилгээний төвийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, болон холбогдох дүрэм журам, стандартын хэрэгжилтийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгч эрсдэлийг тодорхойлон, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчлийг арилгах, эмнэлэг үйлчилгээний ажилчдын ажлын байрны чиг үүргийн хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор асрамжийн төвийн дарга Ц.Баярсайхан, бага эмч сувилагч Б. Нямсүрэн, нярав Н.Сарантуяа, ахлах тогооч Ч.Адъяасүрэн, аргазүйч Н.Дэлгэрмөрөн нарыг байлцуулан төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ.

Шалгалтын явцад дараахь зөрчил дутагдлууд илэрлээ.

Нэг. Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр:

1. Стандартад заагдсан үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн их эмч, эмнэлгийн дээд мэргэжилтэн орон тоогоор болон мэргэшлийн хувьд бүрэн хангагдаагүй байгаа нь Сувиллын бүтэц үйл ажиллагаа MNS5232- 2013 стандартын А хавсралт
2. Эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй хугацаа бүхий тусгай зөвшөөрөлгүй байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 25.1 дахь хэсэг
3. Асрамжийн газар хэрэглэгдэх эмнэлгийн болон бусад тоног төхөөрөмж нь олон ж улсын стандарт шаардлага хангасан гэрчилгээ болон баталгаат бичиггүй байгаа нь Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэх шаардлага MNS 5823:2016 стандартын 5.3 дахь заалтыг
4. Асрамжийн газар нь үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тулгуурласан сэргээн засах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ хэвтрийн асруулагчийн асаргаа, сувилгааны үйлчилгээг зохион байгуулан ажиллаагүй байгаа нь Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэх шаардлага MNS 5823:2016 стандартын 6.4.2 дахь заалтыг

18 0480

5. Асрамжийн газар нь хүний нөөцийг стандартад заасны дагуу / сэргээн засах их эмч /-ийг стандартад заасны дагуу хангаагүй, 25-аас дээш үйлчлүүлэгчтэй боловч гэрээт эмчгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь MNS 5823:2016 стандартын 6.5.3 дахь заалтыг

6. Асрамжийн газарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан нь их эмч мэргэжлээр мэргэжлийн үйл ажиллагааг явуулах зөвшөөрөлгүйгээр ажиллаж байгаа нь MNS 5823:2016 стандартын 6.6.1 дэхь заалтыг

Хоёр. Хоол үйлдвэрлэлийн хяналтаар:

1. Тус төвийн хоол үйлдвэрлэлийн технологийн шат дамжлага нэг чигийн урсгал хангаагүй, халуун болон бохир агаарыг сорох механик агааржуулалтгүй, түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, аяга тавагны угаалга, халуун ажиллагаа, хоол олгох хэсэг нэг дор явагддаг, шаардлагатай өрөө тасалгаагаар хангагдаагүй нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг

2. Хоол үйлдвэрлэлийн ажлын байр, хүнсний агуулах стандартын шаардлага хангахгүй нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Хоолны газрын нийтлэг журмын 4.3 дахь заалтыг

3. Ажлын байр, ажилтны ариун цэвэр, эрүүл мэндэд тавих дотоод хяналт бүртгэлүүд байхгүй нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг

4. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэгчээс хүлээн авдаг ажилтан /нярав/ ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтөлдөггүй, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шинжилгээний дүнг бүрдүүлээгүй нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.6 дахь заалтыг

5. Боловсруулсан хоолны чанарыг шалгах тест, багаж хэрэгслэлээр хангагдаагүй, хяналт тавьсан бүртгэлгүй нь Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал MNS CAC/RCP стандартын 7.5 дахь заалтыг зөрчиж байна.

Иймд дээрх зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн дагуу

ШААРДАХ НЬ:

Нэг. Эмчилгээ чанарын хяналтаар:

1. Стандартад заагдсан үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн их эмч, эмнэлгийн дээд мэргэжилтэн орон тоогоор болон мэргэшлийн хувьд бүрэн хангаж ажиллах

2. Эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй хугацаа бүхий тусгай зөвшөөрөлтөйгөөр үйл ажиллагаа эрхлэх

3. Асрамжийн газар хэрэглэгдэх эмнэлгийн болон бусад тоног төхөөрөмж нь олон улсын стандарт шаардлага хангасан гэрчилгээ болон баталгаат бичиг, тоног төхөөрөмжийн бүртгэл тогтмол хөтөлж хэвших

4. Асрамжийн газар нь үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тулгуурласан сэргээн засах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, хэвтрийн асруулагчийн асаргаа, сувилгааны үйлчилгээг зохион байгуулан ажиллах

5. Асрамжийн газар нь хүний нөөцийг стандартад заасны дагуу /сэргээн засах их эмч /-ийг стандартад заасны дагуу хангаж ажиллах, 25-аас дээш үйлчлүүлэгчтэй тул гэрээт эмчтэйгээр үйл ажиллагаа явуулах

6. Асрамжийн газарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан нь их эмч мэргэжлээр мэргэжлийн үйл ажиллагааг явуулах зөвшөөрөл байх

Хоёр. Хоол үйлдвэрлэлийн хяналтаар:

1. Хоол үйлдвэрлэлийн байрны халуун болон бохир агаарыг сорох механик агааржуулалттай болох, түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, аяга тавагны угаалга, халуун ажиллагаа, хоол олгох хэсгийг тусгаарлах, шаардлагатай өрөө тасалгаагаар хангагдах

2. Хоол үйлдвэрлэлийн ажлын байр, хүнсний агуулахыг стандартын шаардлагын дагуу засварлаж, технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалд нийцүүлэн ажиллах

3. Ажлын байр, ажилтны ариун цэвэр, эрүүл мэндэд тавих дотоод хяналт бүртгэлийг тогтмол хөтөлж хэвших


4. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэгчээс хүлээн авдаг ажилтан /нярав/ ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөх, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шинжилгээний дүнг бүрдүүлэх


Улсын байцаагчийн албан шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн биелэлтийг 2018 оны 01 сарын 20-ны дотор аймгийн Мэргэжлийн хяналтын газарт албан бичгээр ирүүлнэ үү. Дурдсан хугацаанд албан шаардлагын хариу ирүүлээгүй тохиолдолд "Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх" заалтын дагуу арга хэмжээ авахыг мэдэгдье.

АЛБАН ШААРДАГА ГАРГАСАН:


ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  М. АХМАРАЛ

ЭМ БИОБЭЛДМЭЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  Д. АМАРАА

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  А. ЦЭНД-АЮУШ

ХҮНСНИЙ ЧАНАР, СТАНДАРТЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  Ч.ӨЛЗИЙ-ОРШИХ

ТАНИЛЦСАН ХҮЛЭЭН АВСАН.

АХМАД НАСТНЫ АСРАМЖИЙН ТӨВИЙН
ДАРГА  Ц.БАЯРСАЙХАН